



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2017 он 05 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар ХЭГ/812

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат Улсын Их Хурлын 2017 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хөнгөн аж үйлдвэрийг хөгжүүлэх талаарх бодлогын хэрэгжилт, Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл хийх болсныг Танд үүгээр уламжилж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААРХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

2017.05.12

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9943,2 тэрбум төг болж, өмнөх оныхоос 14,1 хувиар өссөн байна. Түүний дотроос боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарын нийт үйлдвэрлэл 2023.0 тэрбумд хүрч аж үйлдвэрийн салбарт эзлэх хувийн жин 20 хувьд хүрсэн.

Хөнгөн үйлдвэрийн салбар ноос ноолуур, арьс шир, мод модон тавилга үйлдвэрлэл, оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэл, барилгын материал, хэвлэл, сав баглаа боодол, дахин боловсруулах, цахилгаан бараа, гоо сайхан, эм, ахуйн химийн болон бэлэг дурсгалын үйлдвэрлэл гэсэн 14 салбарыг хамарч үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна. Тэргүүлэх салбар болох ноос ноолуур, арьс шир, оёдол, мод модон эдлэл нь нийт хөнгөн үйлдвэрлэлийн 60 хувийг эзэлж байна. 2016 оны байдлаар хөнгөн үйлдвэрлэлийн салбарт нийт 2,000 гаруй үйлдвэр үйл ажиллагаа явуулж, 48,000 хүн ажлын байраар хангагдан ажиллаж байна.

Хөнгөн үйлдвэрийн тэргүүлэх салбар нь мал аж ахуйн гаралтай түүхий эдэд тулгуурладаг бөгөөд Монгол Улс 2016 оны тооллогоор 61 сая толгой мал тоолуулж, мал сүргийн тоо өссөнтэй холбоотой малын гаралтай түүхий эдийн нөөц нэмэгдэж байна. 2017 онд малын гаралтай түүхий эд болох ноолуур 9,400 тн, ноос 29,000 тн, арьс шир 14 сая ширхэгийг бэлтгэх урьдчилсан таамаглалтай байна.

Монгол Улсын Засгийн газраас хөнгөн, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарт урт хугацаат хөрөнгө оруулалтын болон санхүү, зээлийн уян хатан бодлого хэрэгжүүлэх зорилт тавьсан бөгөөд энэхүү зорилтын хүрээнд эдийн засгийн өсөлтийг дэмжсэн төслүүдийг санхүүжилтээр хангах хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компанийг байгуулах шийдвэр гаргаад байна. Хөрөнгө оруулалтын сан байгуулагдсанаар хөдөө аж ахуй, хүнс, хөнгөн аж үйлдвэрлэлд суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл бий болгох, ажлын байр болон экспортыг нэмэгдүүлэх зэрэг олон давуу талыг бий болгох юм.

Ноос, ноолуурын үйлдвэрлэлийн салбар:

Ноос, ноолуурын салбарт ноолуур боловсруулах 280, ноос боловсруулах 200 гаруй үйлдвэр, 190 орчим жижиг дунд үйлдвэр, аж ахуйн нэгжид 22700 хүн ажиллаж байгаагийн 90 хувь нь эмэгтэйчүүд, 50 орчим хувь нь 35 хүртэлх насны залуучууд байна.

2016 оны байдлаар ноос, ноолуурын салбар нь нийт үйлдвэрлэлийн хэмжээгээрээ аж үйлдвэрийн салбарын 4.5 хувь, боловсруулах үйлдвэрийн

салбарын 21.8 хувь, хөнгөн үйлдвэрийн салбарын 50 хувийг тус тус эзэлж, 2016 оны байдлаар 387,5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 70 хувийг нь экспортод гаргасан байна.

2016 онд 21 аймгийн 332 сум, Улаанбаатар хотын 6 дүүргийн нийт 102,832 малчин, мал бүхий этгээд 21.6 мян.тн хонины ноос, 1.1 мян.тн тэмээний ноос нийт 22.7 мян.тн ноос бэлтгэн үндэсний 90 үйлдвэрт тушааж 22.6 тэрбум төгрөгийн урамшуулалд хамрагдлаа.

Манай улс 2016 оны байдлаар 9,400 тн ноолуур, 25,000 тн хонины ноос бэлтгэснээс угаасан ноос, ноолуурыг Хятад улс руу, самнасан ноолуурыг Итали, Англи, нэхмэл сүлжмэл бэлэн бүтээгдэхүүнийг Америк, Герман, Солонгос, Япон, Белги, Франц зэрэг 20 гаруй оронд экспортолсон ба нийт экспортын 80 хувийг угаасан ноолуур эзэлж байна.

Ноолуур боловсруулах үйлдвэрүүд жилдээ 12,980 тн ноолуур угаах, 4,606 тн самнах, 1280 тн утас ээрэх, 2,8 сая ширхэг сүлжих, 1868 м нэхэх хүчин чадал суурилагдсан боловч, угаах хүчин чадлаа 100% ашиглаж, самнахын 20%, ээрэхийн 34%, нэхэхийн 25% сүлжихийн хүчин чадлын 70%-ийг ашиглаж байна.

Монгол Улсын стратегийн түүхий эд болох ноолуурын салбарын хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, түүхий эд бэлтгэлийн тогтолцоог сайжруулах, нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг дээшлүүлэх, хүчин чадал нэмэгдүүлэх, технологийн шинэчлэл хийх, үйлдвэрлэлийн эргэлтийн хөрөнгийг шийдвэрлэх, гадаад зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор манай засгийн газар “Ноолуур” хөтөлбөрийг боловсруулж байна.

Арьс ширний үйлдвэрлэлийн салбар:

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын Хан-Уул, Баянгол дүүрэг, Дархан хот гэсэн 3 байршилд арьс шир боловсруулах 34 үйлдвэр, хөдөө орон нутагт арьс ширэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 200 гаруй жижиг дунд үйлдвэрүүд ажиллаж 5,600 орчим хүнийг ажлын байраар хангаж байна.

Арьс шир боловсруулах үйлдвэрлэл нь 20 сая ширхэг арьс хагас боловсруулах, 6 сая ширхэг арьс гүн боловсруулах суурилагдсан хүчин чадалтай бөгөөд 2015 оны байдлаар 2,0 сая ширхэг арьс гүн боловсруулж 169,6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байсан бол 2016 оны жилийн эцсийн байдлаар 4,3 сая ширхэг арьс хагас, 1,6 сая ширхэг арьс гүн боловсруулсан ба боловсруулалтын түвшин 12 хувиар өссөн байна.

Хагас болон гүн боловсруулсан арьс ширний борлуулалт 182 тэрбум, бэлэн бүтээгдэхүүний борлуулалт 77,7 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт 259,5 тэрбум төгрөгийн борлуулалт хийснээс 150 тэрбум төгрөгийн хагас болон гүн боловсруулсан арьс шир, 1,9 тэрбум төгрөгийн савхин цүнх, бээлий, жижиг

эдлэлийн бэлэн бүтээгдэхүүнийг Хятад, Орос, Турк, Казахстан зэрэг орнуудад экспортлоод байна.

Сүүлийн жилүүдэд арьс ширний үйлдвэрлэлийн салбарыг сэргээн хөгжүүлэх талаар төсөл боловсруулж, энэ асуудлаар УИХ-ын болон Засгийн газрын хэд хэдэн тогтоол батлагдан гарсан.

Арьс ширний үйлдвэрлэлийг дэмжих, нүүлгэн шилжүүлэх, түүхий эд бэлтгэл болон малын эрүүл мэнд, түүхий эдийн гарц, бэлтгэлийн тогтолцоог сайжруулах зорилго бүхий 53 төсөлд 80 тэрбум төгрөгийн зээлийг сүүлийн жилүүдэд олгосон ба арьс шир боловсруулах үйлдвэрүүд техник технологийн шинэчлэл хийж бүтээгдэхүүний чанараа сайжруулаад байна.

2016 онд нийт 64,255 малчин, мал бүхий этгээдүүд нийт 3,1 сая ширхэг арьс ширийг үндэсний үйлдвэрүүдэд нийлүүлсэн бөгөөд Засгийн Газраас 10,8 тэрбум төгрөгийг малчдын урамшуулалд олгоод байна.

Арьс ширний үйлдвэрүүдийг үйлдвэрийн шинэ бүс рүү нүүлгэн шилжүүлэх тухай Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоол, Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны 2017 оны 5 сарын 2-ны өдрийн 3 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахаар холбогдох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлж байна.

Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийн салбар:

Оёдлын үйлдвэрлэлийн салбар нь бага дундаж давхаргын эмэгтэйчүүдийг ажлын байраар хангадаг нийгмийн ач холбогдол өндөртэй салбар. 2016 оны жилийн эцсийн байдлаар тус салбарт 1823 ажиллагсад ажиллаж, 31,6 тэрбум төгрөгийн оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2,8 тэрбум төг бараа бүтээгдэхүүн экспортолж, 37,7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд борлуулсан байна.

Оёдлын үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийг 100 хувь импортоор авдаг байсан бол 2017 онд шинээр нэхмэлийн үйлдвэр ашиглалтад орсноор Монгол хонины ноосон болон хагас ноосон даавуугаар сурагчийн дүрэмт хувцас, цэрэг цагдаа, хүчний байгууллагын дүрэмт хувцас болон бусад хувцас хэрэглэлийг үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангах бүрэн боломж нээгдэж байна.

2013-2016 онд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дүрэмт хувцсыг монгол хонины ноосон даавуугаар үндэсний үйлдвэрүүд үйлдвэрлэж нийт сурагчдын 76 хувийг хангаж, хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Мөн 2016 онд цэрэг цагдаа хүчний байгууллага болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудад 5 орчим тэрбум төгрөгийн ажлын болон дүрэмт хувцас, эдлэлийг үйлдвэрлэн нийлүүлсэн.

Оёдлын үйлдвэрүүд жижгэрсэн, хүчин чадал муу байгаатай холбоотой олон тоогоор захиалах гадаад захиалгыг үйлдвэрлэх чадамжгүй байгаа тул Засгийн Газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд оёдлын үйлдвэрүүдийг кластераар хоршин ажиллах замаар хүчин чадлыг нэмэгдүүлэх, франчайз үйлдвэрлэлийг нутагшуулан экспортод чиглэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлээр хөгжүүлэхээр Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрт тусган ажиллаж байна.

Мод, модон эдлэл үйлдвэрлэлийн салбар:

Өнөөдрийн байдлаар мод модон эдлэл үйлдвэрлэлийн салбар 500 үйлдвэр, аж ахуйн нэгжид 5000 орчим хүн ажиллаж байгаа ба 2016 оны жилийн эцсийн дүнгээр 199,0 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулсан байна. Өнөөдөр дотоодын мод, модон материал, тавилгын нийт хэрэгцээний 45 хувийг дотоодын үйлдвэрүүд хангаж, 55 хувийг (74,4 тэрбум төгрөг) импортоор авч байна.

Үйлдвэрийн түүхий эдийн бэлтгэл, хангалтыг орон даяар үйл ажиллагаа явуулж байгаа 800 гаруй ой арчилгаа, цэвэрлэгээний мэргэжлийн байгууллагууд болон ойн нөхөрлөлүүдээр бэлтгэн нийлүүлэлт хийдэг. Нийт мод, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн 31,3% модон тавилга, 28,3% шахмал хавтан, 17,8% барилгын модон хийц, 23,8% түлээний мод, 14,9 % шахмал түлш эзэлж байна.

“Ойн хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх” төслийг Чингис бондын 22,0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлэн ажиллаж байна.

Мөн Засгийн газрын 113-р тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны А/329, А/170 хамтарсан тушаалаар “Ойн цэвэрлэгээ хөтөлбөр” хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, ойг цэвэрлэж, ойн хаягдал түүхий эдийг нөхөрлөлүүдийн хүчээр бэлтгэж, боловсруулан шахмал хавтан, шахмал түлш үйлдвэрлэн эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогыг хэрэгжүүлж байна.

Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбар:

Өнөөдрийн байдлаар нийт 300 орчим хэвлэлийн үйлдвэрт 4000 гаруй хүн ажиллаж байгаа ба 2016 оны байдлаар 15.6 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулжээ. Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарын хувьд хөнгөн үйлдвэрийн бусад салбаруудтай харьцуулахад орчин үеийн дэвшилтэт, дэлхийд тэргүүлэгч Япон, Герман, БНХАУ-ын алдартай техник, технологиуд суурилагдсан ба олон улсын стандартыг хангасан бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа юм.

Хэвлэлийн үйлдвэрлэлийн дотоодын хэрэгцээний 92 хувийг үйлдвэрлэж байгаа ба нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 30% ном сурах бичиг, 20% сонин

сэтгүүл, 5% зар сурталчилгаа, 15% сав баглаа, боодол, шошго, үнэт цаас, 10% бусад хэвлэл эзэлж байна.

Барилгын материалын үйлдвэрлэлийн салбар:

2016 оны жилийн эцсийн байдлаар барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт 850 орчим үйлдвэрт 8000 орчим хүн ажиллаж, 362,0 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулсан байна. Энэ нь хөнгөн үйлдвэрийн салбарын 19,7% эзэлж байна. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн хүндрэл, хямралаас хамааран тус салбарын үйлдвэрлэл өмнөх оны түвшнээс 15-20% хувиар буурсан дүнтэй гарлаа.

2017 оны I улирлын байдлаар цементийн иж бүрэн 5 үйлдвэр, клинкерийн 4 тээрэм ажиллаж байгаа ба дотоодын зах зээлийг 100 хувь хангах боломжтой юм. 2016 онд манай улсын цементийн эрэлтийг дотоодын үйлдвэрүүдээс 740,0 мян тн. импортоор 254.0 мян тн нийт 1,0 сая орчим тн хангаж байсан бол энэ жил дотоодын нийлүүлэлт нэмэгдэж үйлдвэрлэл 1,2 сая тоннд хүрснээр импортыг бүрэн орлож дотоодын үйлдвэрлэлээр хангах боломж бүрдэнэ гэж тооцож байна. Дотоодын үйлдвэрлэлд илүүдэл бий болж байгаатай уялдуулан цемент бетон хучилттай зам тавих, төмөр замын бетон дэр болон цахилгаан дамжуулах агаарын шугамын бетон шонгийн үйлдвэрлэлийг дэмжих замаар нэмүү өртөг бүтээх боломжтой юм.

Арматурын 12 үйлдвэр нийлбэр дүнгээр 12,0 мян тн арматур үйлдвэрлэж зах зээлийн дөнгөж 4 хувийг хангаж 96 хувь буюу 48,5 мян тонныг импортолсон байна

Дотоодын төмөрлөгийн үйлдвэрүүдээр арматурын бэлдэц үйлдвэрлүүлж дотоодын хэрэгцээг хангах шаардлагатай байгаа ба үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр хаягдал төмрөөр арматур үйлдвэрлэх шинэ үйлдвэрийг Налайхын барилгын материалын үйлдвэр технологийн паркад шинээр байгуулж импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих зорилт тавьж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний үйлдвэрүүдээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад барилгын материалын 30 орчим нэр төрлийн бүтээгдэхүүнийг тусгасан.

Барилгын материалын үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлэхэд анхаарч “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрт 8 аймагт элс хайрганы карьер бүхий бетон зуурмагийн үйлдвэр, 12 аймагт дулаан тусгаарлах полистирол бетон гулдмайн жижиг дунд үйлдвэрүүдийг байгуулахаар зорьж байна.

Сав, баглаа боодлын үйлдвэрлэлийн салбар:

Сав баглаа боодлын үйлдвэрлэлийн салбарт 30 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа ба 1000 гаруй хүнийг ажлын байраар хангаж жилдээ

70,0 орчим тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулж, сав баглаа боодлын дотоодын хэрэгцээний 20 хувийг хангаж байна.

Дотоодын үйлдвэрүүд картон хайрцаг, даавуун болон цаасан уут, бэлэгний уут, даавуун цүнх, тор, бүх төрлийн шошго, ундаа усны сав, баглаа, багцлагч хальс, ороогч хальс, бөглөө, хуванцар савны бэлдэц, хүнсний бүтээгдэхүүний гялгар уут, ном, сонин, сэтгүүл, мяндсан шуудай, ПП уут, дотортой, доторгүй, шошго, салфетик, сурагчийн дэвтэр, термаль цаасны үйлдвэрлэл, хуванцар 1 удаагийн аяга, таваг, бичиг хэргийн дугтуй зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Засгийн газрын 287 дугаар тогтоолоор “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулахаар ажиллаж байна. Мөн арга хэмжээний төлөвлөгөөнд сав, баглаа боодлын үйлдвэрийг дэмжин хөнгөлөлттэй зээлд хамруулан импортоор орж ирж буй сав, баглаа боодлыг 80%-иар бууруулах, түүхий эдийн гаалийн татварыг бууруулах зэрэг зорилт тавин ажиллаж байна.

Гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбар:

Монгол Улс 2016 оны байдлаар импортоор 204 тэрбум төгрөгийн гоо сайхан, ахуйн химийн бараа бүтээгдэхүүн импортолсон дүн мэдээ байгаа нь манай улсын дотоодын хэрэглээний 90 хувь импортын бараа бүтээгдэхүүнээс бүрэн хамааралтай байгааг илтгэж байна.

Монгол Улсын хэмжээнд гоо сайхны бүтээгдэхүүн, ахуйн химийн үйлдвэрлэлийн салбарт нийт 30 гаруй үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийт 200 гаруй нэр төрлийн гоо сайхан, ахуйн химийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт үйлдвэрлэлийн хэмжээ 230 орчим сая төгрөгт хүрсэн байна.

Өнөөдөр манай орны онцлог бүхий малын болон ургамлын гаралтай түүхий эд болох чацаргана, зөгийн бал, хонины сүүл, уураг, адууны яс, гүүний эхэсээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл үйлдвэрлэл хөгжиж байна. Мэдлэгт суурилсан, онцгой ялгарал бүхий экспортын чиг хандлагатай, харьцангуй өрсөлдөх чадвар өндөртэй салбар юм.

Хөнгөн үйлдвэрийн салбарт хийгдэх ажлууд:

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасны дагуу “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийг хэрэгжүүлэн импортыг орлох, экспортын чиг хандлагатай 100 үйлдвэрийг орон нутгийн онцлог, түүхий эдийн гарц, хүний нөөц, дэд бүтцийн хөгжлийг үндэслэн байгуулж орон нутгийн иргэдийг нутагтаа орлоготой амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

(Уг хөтөлбөрийг боловсруулж дууссан ба яамдаас санал авахаар хүргүүлээд байна. Хөтөлбөр боловсруулахдаа Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу салбар, салбарын эрдэмтэд, мэргэжлийн холбоод, үйлдвэрлэгчидтэй уулзалт хэлэлцүүлгүүдийг хийж саналуудыг тусгасан. Хөтөлбөрийн боловсруулах ажлын хүрээнд аймгуудын хөдөө, аж ахуйн газрын мэдээлэлд тулгуурлан 2 удаагийн шинэчлэл хийж Монгол Улсын Аж Үйлдвэрлэлийн Зураглалыг хийж гүйцэтгэсэн).

- Монгол Улсын стратегийн бүтээгдэхүүн болох ноолуурын үйлдвэрлэлийг хөгжүүлэн эдийн засаг, нийгмийн ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Ноолуур” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Боловсруулах үйлдвэрийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, хүний нөөцийг чадавхижуулах, ажилгүйдлийг бууруулах “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Хөнгөн үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал


2016 оны эцэс

Салбар	Үйлдвэр	Ажиллах хүчин	Үйлдвэрлэл		Экспорт	Салбарын өсөлт
			л	т		
			Тэрбум төг/	Тэрбум төг/	Тэр.бум төг/	
Ноос, ноолуур	670	22700	987	780	740,0	3.3%
Арьс шир	150	6000	354	297	71.0	0.1%
Оёдол	300	2000	32	44,7	2.8	-20%
Мод	450	5000	148.9	872.8	1.0	0.9%
Барилгын материал	850	8000	362	302,6	0.4	16%
Хэвлэл	300	4000	15,63	15,3	134.1	0,9%
Сав баглаа боодол	30	1000	70,0	68	-	0,9%
Дахин боловсруулах	27	2000	0,5	0,45	0.02	0,8%
Гоо сайхан, ахуйн хими	20	200	0,23	35	0.04	
Нийт	2797	50900	1970.2	2415.85	949.36	

Үйлдвэрүүдийн тоо




Салбарын борлуулалт



Мал, малгаас гаралтай түүхий эдгийн нөөц

5 хошуу мал	Тоо толгой	Арьс, шир	Тоо хэмжээ	Ноос, ноолуур	Тоо хэмжээ
АДУУ	3,635,500	Адууны шир	400,000	Хонинны ноос	23,000 тн
Ухэр	4,081,000	Ухрийн шир	700,000	Ямааны ноолуур	9,200 тн
Тэмээ	401,350	Тэмээний шир	30,000	Тэмээний ноос	1,200 тн
Хонь	27,855,600	Хонинны нэхий	7,400,000	Нийт	33,600 тн
Ямаа	25,570,000	Ямааны арьс	6,200,000		
Нийт	61,550,000	Нийт	14,730,000		



Түүхий эд	Тоо ширхэг	Мөнгөн дүн /Төгрөг/
Ноос	23000 тонн	20 тэрбум
Ноолуур	9200 тонн	736 тэрбум
Арьс шир	10000 сая ширхэг	150 тэрбум
Нийт		906 тэрбум